

БАТЛАВ.  
СУМЫН ХЭЛНИЙ БОДЛОГЫН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА *Т.УРАНБИЛЭГ*

**“ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ТЭЭГЧ, ТҮГЭЭГЧ -2023” ӨДӨРЛӨГ УРАЛДААНЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

2023.10.20.

Тавин

**Үндэслэл:** Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, “Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил ба хос бичгээр хөтлөх”, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтын дагуу төрийн албан хэргийг 2025 оны 01 дүгээр 01-ний өдрөөс хос бичгээр мөрдөх, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор баталсан “ Монгол бичгийн үндэсний хөтөлөр – III”-ийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдыг чадавхжуулахад чиглэгдэнэ.

**Зорилго:** Төрийн албан хаагчдын монгол бичгээр цахимд бичих чадварыг дээшлүүлэх, албан бичиг хэргийг хос бичгээр алдаагүй зөв боловсруулах, хэвлэх, хянах чадварт сургахад оршино.

**Хамрах хүрээ:** Адаацаг сумын төрийн байгууллагын албан хаагчид, иргэд

**Хугацаа:** 2023 оны 10 -11 сард

**Ерөнхий зохион байгуулагч:** Адаацаг сумын хэлний бодлогын салбар зөвлөл

**Сургагч багш:** Монгол бичгийн багш нар болон, Сумын хэлний бодлогын зөвлөлийн дарга, гишүүд

**Нэг. Өдөрлөг, уралдааны зохион байгуулалт**

Өдөрлөг уралдааныг сумын хэмжээнд зохион байгуулна. Сумын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид иргэдийн дунд зохион байгуулна.

Өдөрлөгийн үеэр монгол бичгээр нийтлэгдсэн ном бүтээл, гарын авлага, уран бичвэрийн үзэсгэлэнг гарган ерөнхий боловсролын сурагчид, иргэдэд сурталчлан таниулах, үндэсний хэл бичгээрээ бахархах, сурах идэвх сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглүүлсэн бусад арга хэмжээг зохион байгуулна.

Сумын нэгдсэн өдөрлөгт байгууллагаас оролцох албан хаагчид, иргэд үндэсний хувцастай оролцоно.

**Хоёр. Уралдааны ангилал, төрөл**

Байгууллага, баг бүрээс 8 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцоно. Монгол бичгээр бичсэн лого, энгэрийн тэмдэгтэй байна. Үндэсний өв соёлыг харуулсан багийн мэндчилгээ бэлтгэж ирэх. / Байгууллагын үзүүлэлт болгож оноогоор дүгнэнэ /

“Үндэсний бичгийн тээгч түгээгч” арга хэмжээг дараах ангилалаар зохион байгуулна.

1. “Уран үзэгтэн” монгол бичгийн хичээнгүй бичгийн уралдаан / бичих хугацаа 20 минут/

2. Үндэсний бичгээр “Алтан хонх” танин мэдэхүйн уралдаан

3. Үндэсний бичгийн “Минутын уншлага” / Хүмүн бичиг сонинд бичигдсэн мэдээллээс хамгийн олон үгийг зөв уншсан байдлаар шалгаруулна/

4. Цахим бичвэрийн уралдаанд байгууллага бүрээс 1 төрийн албан хаагч оролцоно /Аймгийн уралдаанд оролцсон төрийн албан хаагч оролцохгүй notebook-тэй Mongolian Baiti Фонтоор “ Монгол бичгийн үндэсний хөтөлөр –III”-ийг бичих

5. Монгол бичгээр дагнан гаргадаг “Хүмүн бичиг” сонины хэрэглээг нэмэгдүүлэхээр /захиалсан төрийн албан хаагчид, байгууллагыг тусгай үнэлгээгээр дүгнэж оноо өгнө.

6. Уран бичлэгийн уралдаан / бүтээл бичих бэлдцийг нэгдсэн журмаар бүх оролцогчдод ижил хэмжээтэй тараана өгөгдсөн текстийг оролцогчид өөрсдийн бийрээр бичнэ /

7. Галигаас / Монгол бичгээр бичих /, гадаад үг унших, бичих

Монгол бичгийн анхан шатны сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо болон сургалтын үнэлгээний дүнгээр байгууллагад оноо өгнө.

### **Гурав. Шагнал урамшуулал**

Өдөрлөг, уралдааны ангилал тус бүрт 1-3-р байр эзлүүлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнана.

Удирдамжинд заасан уралдааны нийлбэр оноогоор тэргүүлсэн эхний 3 байгууллагыг Хэлний бодлогын салбар зөвлөлийн Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж хадгалуулна.

Холбоо барих утас: 94448081, 99982553

**СУМЫН ХЭЛНИЙ БОДЛОГЫН САЛБАР ЗӨВЛӨЛ**